BAYARMAA KHALZAA

TOPICAL

MONGOLIAN

VOCABULARY AND PHRASES

Халзаагийн Баярмаа

МОНГОЛ ХЭЛНИЙ
СЭДЭВЧИЛСЭН ҮГ ХЭЛЛЭГ

Улаанбаатар хот
2023 он

© Халзаагийн Баярмаа 2023
© Энэхүү номыг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр хэвлэн олшруулахыг хатуу хориглоно.

ISBN 978-9919-0-1422-3
ДАА-494
Б-381

Хянасан (Proofreading): Н.Болормаа
Daniel Goldthorpe
Jeffrey King

© Bayarmaa Khalzaa 2023
© This book may not be copied or reproduced without the permission of the copyright owner.

Өмнөх үг

Энэхүү ном нь суралцагчдын үгсийн санг баяжуулах, ярианы чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн ба өдөр тутам хэрэглэгддэг бодит үг хэллэгийг сэдэвчлэн багтаав.

Тухайн сэдвийн хамрах хүрээнээс шалтгаалаад нэр үг, тэмдэг нэр, холбоо үг, тогтмол хэрэглэгддэг өгүүлбэрээс аль тохирохыг нь сонгож, жагсаан оруулсан бөгөөд суралцагчид нь жагсаалтаас өөрт шаардлагатай хэсгийг цээжилж, яриандаа ашиглах боломжтой юм.

Уг номыг бүтээхэд үнэтэй санал, зөвлөгөө өгч тусалсан Н.Болормаа, Daniel Goldthorpe, Jeffrey King, Ewen Kitto нартаа гүн талархлаа илэрхийлье.

Х.Баярмаа

Цахим шуудан: mongolianed@yahoo.com

Preface

This book is aimed at enriching students' vocabulary and improving their speaking skills. It includes real phrases and sentences that are used on a daily basis by topic.

Depending on the scope of the topic, appropriate nouns, adjectives, phrases, or regularly used sentences are selected and listed. Students are encouraged to memorize parts they need from the lists and use them in their speech.

I'm very grateful to N.Bolormaa, Daniel Goldthorpe, Jeffrey King and Ewen Kitto for giving worthwhile advice and help.

Kh.Bayarmaa

E-mail: mongolianed@yahoo.com

Гарчиг

Contents

Өмнөх үг	**Preface 4**
Хүнтэй уулзах, танилцах	**Meeting someone, getting acquainted 5**
Хүнтэй мэндлэх	Greeting someone. 5
Уулзсан хүнээсээ салж явахдаа хэлэх үг хэллэг	Parting ways with someone you have met . . .6
Хүнтэй танилцах	Getting to know someone 7
Таньдаг хүнтэйгээ санам-саргүй таарах	Meeting someone that one knows accidently. 9
Түгээмэл богино нэрс	Common short names . . 11
Талархал илэрхийлэх	**Expressing gratitude . . .12**
Уучлалт хүсэх	**Expressing apologies . . .14**
Харамсаж байгаагаа илэрхийлэх, хүнд сэтгэлийн дэм өгөх	**Expressing regret and sorrow; and giving emotional support to someone. 16**
Нөхцөл байдлыг илэрхийлж хэлэх	**Expressing situations . . .18**
Утсаар ярих	**Talking on the phone . . .19**
Хүнтэй цаг товлож уулзах	**Setting time and meeting someone 21**
Баяр хүргэх, ерөөх	**Congratulating and blessing 22**
Аялга үгс	**Interjections** of emotion **.23**

Тусламж хүсэх	**Asking for help 25**
Чухал шаардлагатай утасны дугаарууд	Important phone numbers. 26
Хот, гудамж	**City and street. 27**
Барилга, бусад зүйлс	Buildings & other things 27
Байгууллага, үйлчилгээний газрууд	Organizations and service units 28
Зарим тэмдэглэгээ	Some designations 30
Орон, зүг чиг заасан үгс	**Postpositions and directions 33**
Хаана	Where 33
Хаашаа	To/towards where 34
Хаагуур	By where 35
Хүнсний дэлгүүр	**Supermarket 36**
Худалдааны төв	**Shopping mall 44**
Хувцас	**Clothes 45**
Нялх хүүхдийн хувцас, хэрэглэл	Baby clothes and accessories 54
Гоо сайхны бараа	**Beauty products. 56**
Зах дээр хэрэглэгддэг үг хэллэг	**Phrases used at outdoor markets. 57**
Бичиг хэргийн дэлгүүр	**Stationery store 58**
Бичгийн хэрэгсэл	Stationeries. 58
Компьютер, интернэт	**Computer and internet .61**
Программ хангамж	Software. 62
Номын дэлгүүр	**Bookshop 64**
Ресторан/зоогийн газар	**Restaurant 67**
Түргэн хоолны газар	**Fast food restaurant 71**

Орон сууц, байр, байшин	**Apartment building, apartment and house . . . 72**
Орон сууц	Apartment 72
Байшин	House 73
Гал тогооны өрөө	**Kitchen 75**
Хоол хийхтэй холбоотой үг хэллэг	Phrases related to cooking 79
Хооллохтой холбоотой үг хэллэг	Phrases related to eating food 81
Угаалгын өрөө	**Bathroom 84**
Зочны өрөө	**Guestroom 88**
Унтлагын өрөө	**Bedroom 90**
Монгол гэр	**Mongolian ger 92**
Монгол хувцас	**Mongolian clothes 95**
Мал аж ахуй	**Animal husbandry 96**
Малын зүс	**Colours of livestock 104**
Мужааны багаж, бусад хэрэгсэл	**Carpentry tools and other tools 106**
Тээврийн хэрэгсэл	**Transport 109**
Суудлын машин	Automobile 109
Галт тэрэг	**Train 115**
Усан замын тээвэр	**Shipping 116**
Агаарын тээвэр	**Air transport 118**
Онгоцны буудал	Airport 119
Автобус	**Buses 121**
Такси	**Taxi 123**
Шуудан харилцаа	**Post office communications 124**
Зочид буудал	**Hotel 126**

Үсчин	**Hairdresser**	**130**
Гоо сайхны салон	**Beauty salon**	**134**
Гэр бүл	**Family**	**136**
Бусад хамаатнууд	Other relatives	137
Насны ангилал	Age category	140
Ажил, мэргэжил	**Jobs and professions**	**143**
Хүний бие	**Human body**	**149**
Эрүүл мэнд	**Health**	**156**
Эмнэлэг	Clinic/hospital	156
Сэтгэлийн хөдөлгөөн, зан ааштай холбоотой тэмдэг нэр, үйл үг	**Adjectives and verbs related to emotion and character**	**164**
Тэмдэг нэр	Adjectives	164
Үйл үг	Verbs	166
Шүүх, гэмт хэрэг	**Court and crimes**	**168**
Байгаль дэлхий	**Nature and the world**	**171**
Улирал, цаг агаар	Seasons and weather	173
Ургамал	**Plants**	**178**
Амьтан	**Animals**	**183**
Спорт/биеийн тамир	**Sports**	**190**
Багийн спорт	Team sports	190
Ганцаарчилсан спорт	Individual sports	196
Эрийн гурван наадам	**Three national sports for men**	**200**
Бөхийн барилдаан	Wrestling	200
Морины уралдаан	Horse racing	201
Сур харваа	Archery	201
Аялал, зугаалга	**Trips and outings**	**203**

Тоглоом	**Games 207**
Үзвэр үйлчилгээ	**Entertainment 211**
Хөгжмийн зэмсгүүд	Musical instruments . . . 216
Телевиз/зурагт	**Television. 218**
Шашин шүтлэг	**Religion. 220**
Буддын шашин	Buddhism 220
Бөө мөргөл	Shamanism. 223
Христ итгэл	Christianity 224
Банк, санхүү	**Bank and finance 226**
Банк	Bank 227
Улс төр, засаг захиргааны нэгж	**Politics and administration units . . .229**
Их сургууль/дунд сургууль	**University/ secondary school 233**
Хэлний хичээл	**Language lesson 239**
Тооны нэр болон холбоотой үг хэллэг	**Numeral and related phrases 243**
Гэрийн хаягаа хэлэх	Telling one's home address. 249
Утасны дугаараа хэлэх	Telling one's phone number 249
Цаг хугацаа	**Time. 250**
Он, сар, өдөр, 7 хоног, хэлэх	Telling years, months, days and weeks. 251
Цаг хэлэх	Telling the time. 252
Ирээдүй цаг	Future time. 253
Өнгөрсөн цаг	Past time 254
Одоо цаг	Current time. 254

Баярууд, мэндчилгээ	**Holidays and greetings 255**
Цагаан сарын мэндчилгээ	Mongolian New Year greetings 256
Үндэсний их баяр наадмын мэндчилгээ	National Naadam Festival greetings 257
Өнгө	**Colours 258**
Геометрийн дүрс	**Geometrical shapes. . . .261**
Хэмжих хэрэгсэл	**Measuring tools 263**
Хэмжих нэгж	Measurement units 263
Хам (жинхэнэ) нэр	Collective nouns 264
Өдөр тутам хэрэглэгддэг зарим богино үг хэллэг	**Some short phrases that are used in everyday speech 265**
Өдөр тутам хэрэглэгддэг үйл үг	**Verbs that are used in everyday speech 270**
Үйл үгийн цагууд	**Verb tenses 279**
Тодорхой тийн ялгалтай хэрэглэгддэг зарим түгээмэл үйл үг	**Some frequently used verbs that require specific noun cases 280**
Дэлхий, улс орнууд	**The world and countries 286**
Улс (нийслэл)	**Countries (capitals) 288**
Аймаг (аймгийн төв)	**Provinces (province centres). 294**
Улаанбаатар хотын дүүргүүд	Districts in Ulaanbaatar city. 295
Ном зүй	**Bibliography 302**

Mongolian	English
Хүнтэй уулзах, танилцах	**Meeting Someone Getting Acquainted**
Хүнтэй мэндлэх	**Greeting someone**
Сайн байна уу?	How are you?
Сайн. Сайн байна уу?	I'm fine. How are you?
Сайн.	I'm fine.
Сайн байцгаана уу?	How are you all?
Сайн уу?	Hi.
Өглөөний мэнд (хүргэе).	Good morning.
Өдрийн мэнд (хүргэе).	Good afternoon.
Оройн мэнд (хүргэе).	Good evening.
Сайхан амарсан уу?	Did you sleep/rest well?
Сайхан. Сайхан амарсан уу?	Yes, I did. Did you sleep/rest well?
Сайхан.	Yes, I did.
Сонин сайхан юу байна?	What's new?
Тайван даа./Юмгүй дээ.	Everything is good./Nothing.
Юу байна (даа)?	What's up?
<u>Цагдаа болон армийн бие бүрэлдэхүүн</u>	<u>Police and army personnel</u>
Амрыг эрье.	Hello.
Та бүхний амрыг эрье.	Hello everyone.
<u>Цагаан сарын мэндчилгээ</u>	<u>Mongolian New Year Greeting</u>
Амар байна уу?	How are you?
Мэнд ээ. Амар байна уу?	I'm fine. How are you?
Мэнд ээ.	I'm fine.

Уулзсан хүнээсээ салж явахдаа хэлэх үг хэллэг

Parting ways with someone you have met

Тантай/чамтай танилцах сайхан байлаа./Сайхан танилцлаа.	It was nice to get to know you.
(Тантай/чамтай) ярилцах сайхан байлаа.	It was a pleasure talking to you.
Тантай уулзсандаа баяртай байна.	I'm happy to meet you.
Тантай уулзах сайхан байлаа.	It was a pleasure meeting you.
Баяртай.	Goodbye/bye.
Би одоо хичээлтэй. **Дараа нь** уулзъя.	I have a lesson now. See you **after that**.
Дараа уулзъя	See you **later**.
Удахгүй уулзъя.	See you soon.
Дараа ярьж байгаад нэг уулзъя.	Let's keep in contact and meet sometime later.
Баяртай. Маргааш уулзъя.	Bye. See you tomorrow.
Түр баяртай.	Bye for now.
Битгий сураггүй алга болчхоорой.	Don't disappear without any news.
Холбоотой байгаарай.	Please keep in touch.
Өдрийг сайхан өнгөрүүлээрэй.	Have a nice day.
Сайхан амраарай.	Good night./Have a good rest.
Сайн амраарай.	Rest well.

Би явах хэрэгтэй болчихлоо.	I've got to get going.
За, би явлаа.	Okay, I'm heading off.
Биеэ сайн бодоорой.	Take good care of yourself.
Болгоомжтой яваарай.	Go carefully./Drive carefully.
Хурдан эдгээрэй.	Get well soon.
Дараа утсаар ярья.	I will call you later.
Удахгүй холбоо барина аа.	I will contact you soon.
Сайн яваарай.	Have a good trip (one way).
Сайн яваад ирээрэй.	Have a good trip (2 ways).
Сайн сууж байгаарай.	Stay well.

Хүнтэй танилцах / Getting to know someone

Таны/чиний нэр хэн бэ?	What is your name?
Миний нэр ...	My name is ...
Таныг/чамайг хэн гэдэг вэ?	What is your name?
Намайг ... гэдэг.	My name is ...
Миний бүтэн нэр **А**маржаргал, богино нэр **Аа**гий. Хүмүүс намайг Аагий гэж дууддаг. (Та) намайг Аагий гэж дуудаж болно оо.	My full name is Amarjargal and my short name is Aagii. People call me Aagii. You can call me Aagii.
Та/чи аль улсаас ирсэн бэ?	What country are you from?
Та/чи хаанаас ирсэн бэ?	Where are you from?
Би Америкаас ирсэн.	I'm from America.
Би америк хүн.	I'm American.
Та орос хүн үү?	Are you Russian?
Би орос биш, америк хүн.	I'm American, not Russian.

Чи/та хэдэн настай вэ?	How old are you?
Би 35 настай.	I'm 35 years old.
Та ямар шугамаар/ажлаар Монголд ирсэн бэ?	For what purpose did you come to Mongolia?
Би ажлын шугамаар ирсэн.	I came here for work.
Би энд хэл сурахаар ирсэн.	I came here to learn the language.
Би их сургуульд сурахаар ирсэн.	I came here to study at the university.
Би сайн дурын ажил хийхээр ирсэн.	I came here to do volunteer work.
Би найзындаа ирсэн.	I came to visit my friend.
Та Монголд ирээд хэр удаж байна (вэ)?	How long have you been in Mongolia?
Би Монголд ирээд 6 сар/1 жил болж байна.	It has been 6 months/1 year since I came to Mongolia.
Та энд удах уу?	Will you stay here long?
Энд нэлээн/нэлээд удна.	I will stay here quite a long time.
Энд нэг их удахгүй.	I will not stay here that long.
(Би энд) 3 жил болно.	I will stay here for 3 years.
Та Монголд хэр удсан бэ?	How long did you stay in Mongolia?
Нэлээн/нэлээд удсан.	I stayed quite a long time.
Нэг их удаагүй.	I didn't stay that long.
Би тэнд 3 жил болсон.	I stayed there for 3 years.
Монгол ямар байна (вэ)?	How is Mongolia?
Монгол улс сайхан/сонирхолтой юм байна.	Mongolia is nice/interesting.

Та ямар ажил хийдэг вэ? — What do you do?
Би дунд сургуульд багшилдаг. — I work in a secondary school as a teacher.
Та ямар мэргэжилтэй вэ? — What is your profession?
Би багш. — I'm a teacher.

Та хаана амьдардаг вэ? — Where do you live?
Би 1 дүгээр хороололд амьдардаг. — I live in the apartment complex #1.
Танайхан хэдүүлээ амьдардаг вэ? — How many of you live together?
Манайхан олуулаа/цөөхүүлээ амьдардаг. — Many/a few of us live together.
Чи/та хэн хэнтэйгээ амьдардаг вэ? — Who do you all live with?
Би нөхөртэйгөө/эхнэртэйгээ/хүүтэйгээ/охинтойгоо амьдардаг. — I live with my husband/wife/son/daughter.
Би ганцаараа амьдардаг. — I live alone.

Та монгол хэл мэдэх үү? — Do you know Mongolian?
Би монгол хэл жаахан/сайн мэднэ. — I know Mongolian a little/well.
Та монголоор ярьдаг уу? — Do you speak Mongolian?
Би монголоор сайн ярьдаггүй. — I don't speak Mongolian well.

Таньдаг хүнтэйгээ санамсаргүй таарах — **Meeting someone that one knows accidently**

Сайн уу? Ямар сонин хүн бэ! — Hi, stranger!
Энд чамтай/тантай таарна гэж бодсонгүй шүү. — I didn't expect to see you here.

Чамтай уулзах юмсан гэж бодож байлаа.	I was hoping to meet you.
Уулзалгүй удсан байна шүү./Уулзалгүй уджээ.	Long time no see.
Харин тийм ээ, уулзалгүй удсан байна.	You are right. Long time no see.
(Чамтай/тантай) уулзах сайхан байна аа.	It is nice to see you.
Танайхан сайн уу?	How is your family?
Бүгдээрээ сайн байгаа, баярлалаа.	All are well, thank you.
Батад мэнд хүргээрэй.	Please say hi to Bat for me.
Тэгнэ ээ. Мэнд хүргэнэ ээ.	Yes, I will say hi to him.
Таныг/чамайг найзтайгаа танилцуулах гэсэн юм. (Түүнийг) Отгоо гэдэг.	I would like to introduce my friend to you. His name is Otgoo.
Чи Баттай уулзаж байгаа юу?	Have you been seeing Bat?
Би Баттай уулзаж байгаа.	I have been seeing Bat.
Бид хоёр байнга уулзалддаг.	We (two of us) meet often.
Бид хоёр хааяа нэг уулзалддаг.	We (two of us) meet occasionally.
Би Баттай уулзахгүй байгаа.	I have not been seeing Bat.
Батаас сурагтай юу?	Have you heard any news from Bat?
Батаас сураггүй л байна.	I have not heard any news from Bat.

Чи намайг танихгүй байна уу?	Don't you recognize me?
Харин хэн билээ?	Who are you, again?
Би Бат байна аа. Өнгөрсөн жил Болдын төрсөн өдөр дээр таарсан шүү дээ.	I'm Bat. We met at Bold's birthday last year.
Аа, одоо саналаа, саналаа.	Oh, I remember you now.
Түгээмэл богино нэрс	**Common short names**
Отгонцэцэг - Отгоо - **Оо**гий	**O**tgontsetseg - Otgoo - **Oo**gii
Болорцэцэг - Болороо - **Боо**гий	**Bo**lortsetseg - Boloroo - **Boo**gii
Баярхүү - Баяраа - **Баа**гий	**Ba**yarkhuu - Bayaraa - **Baa**gii
Ууган... - Ууганаа - **Уу**гий	**Uu**gan... - Uuganaa - **Uu**gii
Наранцэцэг - Нараа	Narantsetseg - Naraa
Саранцэцэг - Сараа	Sarantsetseg - Saraa
Одончимэг - Одоноо	Odonchimeg - Odonoo
Отгон/ууган	The oldest/the youngest
Баяр-хүү	Holiday/happiness-son
Болор-цэцэг	Crystal-flower
Наран-цэцэг	Sun-flower
Саран-цэцэг	Moon-flower
Одон-чимэг	Star-ornament
Төвд үг орсон нэрс	**Names used Tibetan words**
Даваа... - **Даа**гий/Даавка	Monday (The Moon)
Мягмар... - Мягаа [Мийгаа]	Tuesday (Mars)
Лхагва... - Лхагваа	Wednesday (Mercury)
Пүрэв... - Пүрэвээ/Пүүжээ	Thursday (Jupiter)
Баасан... - Бааска/Баагий	Friday (Venus)
Бямба... - Бямбаа	Saturday (Saturn)
Ням... - Нямаа/Нямкаа	Sunday (The Sun)
Долгор-маа	White goddess-mother

Талархал илэрхийлэх

Expressing Gratitude

(Чамд/танд) баярлалаа.	Thank you.
Их баярлалаа.	Thank you very much.
Маш их баярлалаа.	Thank you so much. (More expressive)
Үнэхээр их баярлалаа.	Thank you very much indeed.
Үнэхээр талархаж байна.	I really appreciate it.
Гялайллаа.	Thank you. (Formal)
Би танд чин сэтгэлээсээ баярлаж/талархаж байна.	I thank/appreciate you with all of my heart.
Би танд үргэлж баярлаж/талархаж явдаг.	I'm always thankful to you.
Манайд ирсэнд баярлалаа.	Thank you for coming to my house.
Надтай ирж уулзсанд баярлалаа.	Thank you for coming to see me.
Цаг гаргасанд баярлалаа.	Thank you for your time.
Тусалсанд баярлалаа.	Thank you for your help.
Бэлэг өгсөнд баярлалаа.	Thank you for the gift.
Урмын үг хайрласанд баярлалаа.	Thank you for the words of encouragement.
Гэртээ урьсанд баярлалаа.	Thank you for inviting me to your home.
Амттай хоолоор дайлсанд баярлалаа.	Thank you for the delicious food.
Имэйл бичсэнд баярлалаа.	Thank you for your email.
Утсаар ярьсанд баярлалаа.	Thank you for calling me.
Асуусанд/хэлсэнд баярлалаа.	Thank you for asking/telling me.

Үнэтэй зөвлөгөө өгсөнд баярлалаа.	Thank you for giving me valuable advice.
Сайхан санаа хэлж өгсөнд баярлалаа.	Thank you for giving me a good idea.
Төрсөн өдрийн баярт маань хүрэлцэн ирсэнд баярлалаа.	Thank you for coming to my birthday party.
Баярлалаа. Чи миний төлөө маш их зүйлийг хийж өглөө.	Thank you. You did so many things for me.
Баярлалаа. Чиний тусыг хэзээ ч мартахгүй ээ.	Thank you. I will never forget your help.
Баярлалаа. Чамайг байгаагүй бол би яах байсан юм бол оо!	Thank you. I wonder what I would do without you!
Чиний ачийг яаж хариулахаа мэдэхгүй л байна.	I don't know how to repay your help.

Хариу үг хэллэг	**Responses**
Зүгээр ээ./Зүгээр зүгээр.	You are welcome.
Зүгээр ээ. Туслалгүй яах вэ дээ! [яахуудээ]	You are welcome. Of course, I want to help you.
За, тийм юм байлгүй яах вэ дээ.	Well, this is a normal thing to do.
Зүгээр дээ. Энэ зэргийн тус байлгүй яах вэ дээ.	No worries. Of course, I want to give you this little help.
Зүгээр ээ. Нэг их том бэлэг биш шүү дээ.	Don't worry. This is not a big gift.
Зүгээр ээ. Харин ч илүү их тус хүргэж чадсангүй.	You're welcome. I wish I could have done more.

Уучлалт хүсэх	Expressing Apologies
Уучлаарай.	Sorry.
Намайг уучлаарай.	I'm sorry.
Өршөөгөөрэй.	Excuse me.
Намайг үнэхээр уучлаарай.	I'm really sorry./Please forgive me.
Уучлаарай. Миний буруу.	I'm sorry. It is my fault.
Үнэхээр миний буруу.	It is really my fault.
Хоцорч ирсэнд уучлаарай.	I'm sorry for being late.
Номыг чинь удаасанд уучлаарай.	I'm sorry for keeping your book for a long time.
Танайд очиж чадаагүйд уучлаарай.	I'm sorry I could not visit your home.
Чамд тусалж чадахгүй байгаад уучлаарай.	I'm sorry for not being able to help you.
Цагийг нь тулгаж хэлсэнд/асуусанд уучлаарай.	Sorry for telling/asking you at short notice.
Урьдчилж хэлээгүйд уучлаарай.	Sorry for not telling you in advance.
(Танд) төвөг удаж байгаад уучлаарай.	I'm sorry for disturbing you.
Үгийг чинь тасалчихлаа, уучлаарай.	I'm sorry for cutting you off.
Хэлсэндээ хүрч чадаагүйд уучлаарай.	I'm sorry I could not keep my promise.
Таныг гомдоохыг хүсээгүй юм шүү.	I didn't mean to offend/hurt you.
Чадвал намайг уучлаарай.	Forgive me if you can.

Харалгүй өнгөрсөнд уучлаарай.	I'm sorry I passed by you without noticing.
Уучлаарай. Хэлснийг чинь буруу ойлгосон байна.	I'm sorry. I misunderstood what you said.
Уучлаарай. Хэлсэн үгэндээ би үнэхээр харамсаж байна.	I'm sorry. I really regret what I have said.
Уучлаарай. Хийсэн зүйлдээ би үнэхээр гэмшиж байна.	I'm sorry. I'm really feeling guilty about what I have done.
Миний өмнөөс найзаасаа уучлалт гуйгаарай.	Please ask your friend for forgiveness for me.

Хариу үг хэллэг	**Responses**
Өө, зүгээр ээ.	Oh, no problem.
Өө, зүгээр зүгээр.	Oh, no problem.
Зүгээр ээ, би юм санаагүй.	No problem. I did not take it seriously.
Зүгээр ээ, чамайг ойлгож байна аа.	No problem. I understand you.
Зүгээр ээ, битгий санаа зов.	No problem. Don't worry about it.
Зүгээр ээ. Завгүй байгааг чинь би мэдэж байгаа.	No problem. I know you are busy.
Зүгээр ээ. Харин ч би чамаас уучлалт гуйх ёстой.	No problem. I'm the one who should ask you for forgiveness.
Зүгээр ээ. Санаатай тэгээгүйг чинь би мэдэж байгаа.	No problem. I know that you didn't do it intentionally.
Зүгээр ээ. Ийм юм байх.	No problem. This happens.

Харамсаж байгаагаа илэрхийлэх, хүнд сэтгэлийн дэм өгөх

Expressing Regret and Sorrow; and Giving Emotional Support to Someone

Ээ!	Eh!/Oh!
Өө, ямар харамсалтай юм бэ!	Oh, what a pity!
Ээ, тоогүй юм болжээ.	Eh, that is too bad.
Өө, тийм үү?	Oh, really?
Өө, яана аа!	Oh, no!
Ээ, хөөрхий дөө.	Oh, poor thing.
Ээ, бурхан/тэнгэр минь!	Oh, my god!
Өө, ямар балай юм бэ!	Oh, what a bummer!
Найздаа тусалж чадаагүйдээ би үнэхээр харамсаж байна.	I really regret that I could not help my friend.
Найздаа тусалж чадахгүй байгаадаа би үнэхээр гэмшиж байна.	I'm really feeling guilty about not being able to help my friend.
Найздаа тусалдаг байж.	I should have helped my friend.
Чи хичээлээ сайн давтахгүй дээ!	You should have reviewed your lessons well!
Харин тийм ээ. Хичээлээ сайн давтдаг байж.	You are right. I should have reviewed my lessons well.
Тийшээ явдаггүй байж.	I should not have gone there.
Тэгдэг байж.	I should have done that.
Тэгдэггүй байж.	I should not have done that.
(Би) машинтай ч байсан болоосой.	I wish I had a car.

(Би) монголоор сайн ярьж чаддаг ч байсан болоосой.	I wish I were able to speak Mongolian well.
Чамд ямар байгааг би ойлгож байна аа.	I understand how you feel.
Тайвшир даа.	Calm down.
Битгий санаа зовоорой.	Please don't worry.
Ийм асуудал болсонд чиний буруу гэж байхгүй.	It is not your fault that this problem happened.
Амьдралд янз бүрийн зүйл тохиолдож л байдаг шүү дээ.	Different things happen in life.
Асуудлыг шийдэх ямар нэгэн арга байж л таараа.	There must be some way to solve the problem.
Алдаагаа залруулах боломж гарах байлгүй дээ.	There must be a chance for you to correct your mistake.
Боломжгүй зүйл/болохгүй юм гэж байхгүй.	Nothing is impossible.
Бүх юм сайхан болно оо.	Everything will be good.
Одоо тэгээд яах вэ?	What shall we do now then?
Одоо өнгөрсөн. Зүгээр орхи, орхи.	Now it is too late. Just leave it that way.
Одоо яах ч аргагүй болсон. Сэтгэлээр битгий уна.	Now there is no way to change it. Don't be disappointed.
Одоо ямар ч нэмэргүй.	Nothing can help it now.
Тэр тухай бодохгүй байхыг хичээгээрэй.	Please try not to think about that.
Юу гэж хэлэхээ мэдэхгүй л байна.	I don't know what to say.
Итгэл найдвараа битгий алдаарай.	Please don't lose hope.
Өөдрөг байгаарай.	Please be optimistic.

Нөхцөл байдлыг илэрхийлж хэлэх

Expressing Situations

(Таны) ажил сайн уу?	Is your work going well?
Амьдрал хэр байна (вэ)?	How is your life going?
(Миний) ажил сайн.	My work is good.
Амьдрал дажгүй байгаа.	My life is pretty good.
Бүх зүйл хэвийн (байгаа).	Everything is normal.
Бүх зүйл сайн байгаа.	Everything is well.
Бүх зүйл зүгээр байгаа.	Everything is all right.
Бүх юм байдгаараа л байна.	Everything is same as usual.
Маш/их сайн байгаа.	It is very well.
Үнэхээр сайн байгаа.	It is really well.
Муугүй/гайгүй байгаа.	It is not bad.
Бодож байснаас хавьгүй дээр байгаа.	It is way better than I was expecting.
Гайхамшигтай байгаа.	It is wonderful.
Ямар ч асуудалгүй л байна.	There isn't any problem.
Өө яах вэ, болж л байна.	Well, it is going okay.
Дээрдэж байгаа.	It is getting better.
Муу байгаа.	It is bad.
Асуудал ихтэй л байна.	There are lots of problems.
Яах вэ дээ (л байгаа).	So so.
Тиймэрхүү л байна.	It is not so great.
Тааруухан л байна.	It is not so well.
Тун тааруу байгаа.	It is really bad.
Жаахан хэцүү л байна.	It is a little difficult/tough.
Сайнгүй л байна.	It is not so good.
Аймшигтай байгаа.	It is terrible.

Миний ажил хэцүү.	My work is difficult. (In general)
Миний ажил хэцүү байгаа.	My work is difficult. (Continually)
Миний ажил хэцүү байна.	My work is difficult. (At the moment)

Утсаар ярих	Talking on the phone
Байна уу?	Hello? (Is someone there?)
Байна.	Hello? (Here I am.)
Сайн байна уу?	How are you?
Сайн. Сайн байна уу?	Good. How are you?
Хэн бэ?	Who is it?
Би байна аа.	It is me.
(Би) Туяа байна аа.	It is Tuya. (I'm Tuya.)
Бат гэж/гэдэг хүний утас мөн үү?	Is this the phone number of someone named Bat?
Мөн байна.	Yes, it is.
Та Дорж багш уу?	Are you the teacher Dorj?
Тийм байна. Хэн бэ?	Yes, I am. Who is it?
Би Гэрэлмаагаас таны утасны дугаарыг авсан юм.	I got your phone number from Gerelmaa.
Танаас юм лавлах/асуух гэсэн юм.	I wanted to inquire/ask you something.
Та дугаар андуурчихжээ.	You got the wrong number.
Та буруу залгачихжээ.	You dialed the wrong number.
Оргилын утасны дугаарыг хэлээд өгөөч.	Can you please tell me the phone number of Orgil?
(Би) тийм хүн танихгүй.	I don't know such a person.
Тийм хүн байдаггүй.	There is no such person here.
Байна уу? Байна уу?	Hello? Hello?
Сонсогдохгүй байна.	I can't hear you.
Ай? Юу гэнэ ээ?	Huh? What did you say?
Дуу чинь бүр алга болчихлоо.	I can't hear your voice at all.

Сүлжээ орж гараад байна.	The network is cutting in and out.
Манай энд сүлжээ их муу барьдаг.	Our network here is very bad.
Саяа миний утас тасарчихлаа, уучлаарай.	I'm sorry. My phone was just cut off.
Би утсаа саяа л асаалаа.	I just turned my phone on.
Сайн сонсогдохгүй байна. (Би) утсаа салгаад, чам руу дахиад залгая.	I can't hear you well. Let me hang up and call you back.
Та над руу ярьсан байсан. Одоо л зав гараад залгаж байна.	I saw that you called me. Just now I have time and I'm calling you.
Чи яагаад утсаа авахгүй байсан юм бэ?	Why were you not answering your phone?
Уучлаарай. Утасныхаа дууг хаачихсан байсан болохоор дуудлага ирснийг мэдсэнгүй.	I'm sorry. I didn't know I had a call from you because I had muted my phone.
Уучлаарай. Завгүй байгаад утсаа саяа л харлаа.	I'm sorry. I was busy and I just looked at my phone now.
Зүгээр л мэнд мэдэх гээд залгаж байна.	I'm just calling you to say hi.
Завтай үедээ над руу залгаарай.	Call me when you have time.
Гэртээ очоод мессеж бичээрэй.	Text me when you get home.
Бат аа! Утас чинь дуугараад байна. Утсаа ав.	Bat! Your phone is ringing. Answer your phone.
Танихгүй дугаар байна.	It is an unknown number.

Хүнтэй цаг товлож уулзах	Setting Time and Meeting Someone
Ойрд хоёулаа уулзсангүй. Удахгүй нэг уулзацгаая.	We (two of us) have not seen each other lately. Let's meet up soon.
Чи маргааш орой 6 гээд завтай юу?	Do you have time tomorrow evening around 6?
Маргааш завгүй. Харин нөгөөдөр орой завтай.	I'm busy tomorrow. But I have time the day after tomorrow in the evening.
Тэгвэл нөгөөдөр 6 цагт нөгөө уулздаг ресторандаа уулзъя.	Let's meet at 6 pm in the restaurant we usually meet then.
За, тэгье.	Okay, let's do that.
(Би) чамтай уулзахыг тэсэн ядан хүлээж байна.	I'm looking forward to seeing you.
Би ирчихлээ.	I have just arrived./I'm here.
Чи ирж байна уу?	Are you coming?
(Би) очиж байна аа.	I'm coming (getting there).
Зам түгжрээтэй байна. Би жаахан хоцрох нь ээ.	There is a traffic jam. I think I will be a little late.
Одоо хаана явж байна?	Where are you now?
Нэг их хол биш. 5 минутын дараа оччих байх.	Not too far. Probably I will be there in 5 minutes.
Хүлээлгэчихлээ, уучлаарай.	Sorry I made you wait.
Хоцорчихлоо, уучлаарай.	Sorry, I'm late.
Зүгээр зүгээр. Би түрүүхэн ирсэн.	No problem. I just came a few minutes ago.
Зүгээр ээ, би бас саяхан ирлээ.	It's okay. I just arrived now too.
Би эрт/цагтаа ирсэн.	I came early/on time.
Уулзах сайхан байна шүү.	Nice to see you.

Баяр хүргэх, ерөөх	Congratulating and Blessing
Баяр хүргэе!	Congratulations!
Чин сэтгэлээсээ баяр хүргэе!	Sincere congratulations!
Чин сэтгэлийн угаас баяр хүргэе.	Congratulations from the bottom of my heart!
Халуун баяр хүргэе.	Warm congratulations.
Хүүхэдтэй болсонд чинь баяр хүргэе!	Congratulations for having a new baby!
Сургуулиа амжилттай төгссөнд чинь баяр хүргэе.	Congratulations on your successful graduation.
Шинэ ажилд орсонд чинь баяр хүргэе.	Congratulations on your new job.
Хуримаа хийсэн гэж сонслоо. Баяр хүргэе!	I heard that you had your wedding. Congratulations.
Тэмцээнд түрүүлсэнд чинь баяр хүргэе.	Congratulations on winning the competition.
Бат чамд баяр хүргэж байна (би)лээ.	Bat passes on congratulations to you.
Амжилт хүсье!	Good luck!
Танд сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!	I wish you all the best!
Танд аз жаргал, эрүүл энхийг хүсэн ерөөе!	I wish you happiness and good health!
Танд ажлын амжилт хүсэн ерөөе!	I wish you success in your work!
Эрүүл мэндийн төлөө!	For health! (For toasting)
Ажлын амжилтын төлөө!	For success in work!
Төлөө!	Cheers!

Аялга үгс

Interjections of Emotion

Аа.
Аа, одоо ойлголоо.

Aha. (Understanding)
Aha, I got it now.

Ай?
Ай? Юу гэнэ ээ?

Huh?
Huh? What did you say?

За./За аа, за.
За. Би заавал очно оо.

Okay.
Okay. I will go there for sure.

За, за.
За, за. Ойлголоо. Битгий үглээд бай.

Okay, okay
Okay, okay. I got you. Don't keep on nagging.

Ээ хөөрхий!/Ээ зайлуул!
Ээ хөөрхий дөө! Тэр яагаад уначхав аа?

Oh, poor thing! (Pitying)
Oh, poor thing! Why did he just fall?

Өө./Ээ.
Өө, чи ийшээ ирж чадахгүй юм уу?

Oh. (Regretting)
Oh, can't you come here?

Хөөе!/Хүүе!/Хүүш! ... аа[4]!
Хүүе! Хүлээж бай.
Ах аа! Нааш ир.
Бат аа! Чи хаана байна аа?

Hey! (Calling)
Hey! Wait for me.
Brother! Come here.
Bat! Where are you?

Хөөх!
Ооё!
Хөөх! Ямар гоё газар вэ!
Ооё, чи ёстой мундаг байсан байна.

Wow! (Surprising)
Wow! (Little sarcastic)
Wow! What a nice place!
Wow, you were great.

Ёо!
Ёо, ямар их өвдөж байна аа!

Ow! (Feeling pain)
Ow! It hurts a lot.

Ёх!/Ёох!
Ёох, суух ямар гоё юм бэ!
Ёх, санаа амарлаа.

Ahh!/Oh! (Relaxing)
Ahh! It is so nice to sit down.
Oh, I'm relieved.

Ха, ха/хи, хи
Ха, ха. Ямар инээдтэй юм бэ!

Ha-ha/he-he (Laughter)
Ha-ha. What a funny thing it is!

Паах!/Пөөх!
Паах! Ямар муухай алчуур вэ!
Пөөх! Ямар муухай үнэртэй юм бэ!

Yuck!/Ugh!/Phew (Disgusting)
Yuck! What a disgusting towel it is!
Phew! What a bad smell!

Халхай!/Халцгай!
Халхай, халхай! Гадаа ямар халуун байна аа.
Халцгай, халцгай! Гараа түлчихлээ.

Phew!/Ouch! (Feeling hot)
Phew! It's hot outside!
Ouch! I just burned my hand.

Тий, тий!
Тий, тий! Хүйтэн байна. Цонхоо хаа.

Brr! (Feeling cold)
Brr! It is cold. Close the window.

Ий!/Айжуу!
Ий! Чи надаас айв уу?
Айжуу!
Айжуу! Гадаа мангас байгаа шүү. Битгий гадаа гар.

Aah! (Having fear)
Aah! Were you afraid of me?
(For little kids)
Aah! There is a monster out there. Don't go outside.

Тусламж хүсэх

Asking for Help

Хүн байна уу? Туслаарай.

Is there anyone? Help!

Энд халаасны хулгайч байна!

There is a pickpocket here!

Тэр хүнийг бариад аваарай! Миний цүнхийг булаачихлаа.

Catch/stop that person! He took my bag by force.

Туслаарай! Энэ хүн намайг дагаад байна.

Help! This person keeps following me.

Уучлаарай, би сая утсаа хулгайд алдчихлаа. Утсаар чинь ярьж болох уу?

Sorry, my phone has just been stolen. Can I use your phone?

Би дөнгөж сая мөнгөө дээрэмдүүлчихлээ. Цагдаа дуудаад өгөөч.

A robber has just robbed my money. Can you please call the police for me?

Түргэн дуудах гэсэн юм. Утасны дугаар нь хэд юм бол?

I want to call an ambulance. What is the phone number?

Та нэг зүйл дээр надад туслаад өгөөч.

Can you please help me with one thing?

Танаас нэг юм гуйх гэсэн юм.

I want to ask you for something.

Би Бат гэж хүнтэй уулзах гэсэн юм. Дуудаад өгөөч.

I want to meet a person called Bat. Can you call him for me?

Танаас юм асуух/лавлах гэсэн юм. Энд ойрхон хүнсний дэлгүүр байдаг уу?

I want to ask you/clarify something. Is there a supermarket nearby?

Чухал шаардлагатай утасны дугаарууд	**Important phone numbers**
101 - Гал түймэртэй тэмцэх газар	Fire Fighting Department
102 - Цагдаагийн газар	Police Station
103 - Нийслэлийн яаралтай тусламжийн төв	Emergency Ambulance
105 - Гамшиг ослын дуудлага	Natural calamity and disaster
107 - Гэр бүлийн хүчирхийллийн газар	Domestic Violence Centre
108 - Хүүхдийн тусламж	Help for children
100 - Халдвартын түргэн тусламж	Contagious disease help
1971 - Хувийн түргэн тусламж	Private ambulance
70112100 - Тээврийн цагдаагийн алба	Traffic Police Service
1800-1105 - Онцгой байдлын ерөнхий газар	National Emergency Management Agency
1900-1950 - Нэгдсэн лавлах	General Information Centre
1900-1980 - "Чингис хаан" олон улсын нисэх буудлын лавлах	"Chingis Khaan" International Airport Information Centre
1900-1234 - Авто тээврийн нэгдсэн лавлах	General Transport Information Centre
1900-1949 - Төмөр замын лавлах	Railway Information Centre

Хот, гудамж

City and Street

Барилга, бусад зүйлс

Buildings and other things

Өргөн чөлөө	Avenue
Гудамж	Street
Засмал зам	Paved road (for cars)
Шороон зам	Dirt road
Төв зам	Main road
Туслах зам	Side road
1 дүгээр/2 дугаар эгнээ	First/second lane
Хурдны зам	Highway
Явган хүний зам	Sidewalk
Гарц	Zebra crossing
Гүүрэн гарц	Bridge crossing
Нүхэн гарц	Underground crossing
Гэрлэн дохио	Traffic light
Гудамжны гэрэл	Streetlight
Гүүр	Bridge
Хогны сав	Trash bin
Замын хашлага	Railings
Замын тэмдэглэгээ	Road sign
Хөшөө	Statue
Гүүр	Bridge
Тоглоомын талбай	Playground
Цэцэрлэгт хүрээлэн	Park
Автобусны буудал	Bus stop
Галт тэрэгний буудал	Train station
Вокзал	Train station
Нисэх онгоцны буудал	Airport
Машины зогсоол	Parking lot
Унадаг дугуйн зогсоол	Bicycle parking
Гарааш	Garage
Хяналтын камер	Surveillance camera

Сурталчилгааны самбар	Advertisement board
Барилга	Building
Орон сууц	Apartment building

Байгууллага, үйлчилгээний газрууд	**Organizations and service units**
Шатахуун түгээгүүр	Petrol station
Карт цэнэглэх, борлуулах цэг	Kiosk for charging and selling bus cards
Сонин, сэтгүүл борлуулах цэг	Kiosk for selling newspapers and magazines
ТҮЦ (Түргэн Үйлчилгээний Цэг)	Kiosk for selling small products
Хүнсний <u>дэлгүүр</u>/<u>бараа</u>	Grocery store
Барааны дэлгүүр	Misc. products store
Бичиг хэргийн дэлгүүр	Stationery store
Бэлэг дурсгалын дэлгүүр	Souvenir shop
Номын дэлгүүр	Bookstore
Хуучин номын худалдаа	Second hand book seller
Номын сан	Library
Эмийн сан	Pharmacy
Үсчин	Hairdresser
Гоо сайхан	Beauty salon
Саун, массаж	Sauna and massage
Ломбард	Pawnshop
Цайны газар	Small restaurant
<u>Зоогийн газар</u>/ресторан	Restaurant
Түргэн хоолны газар	Fast food
Гуанз	Small restaurant
Кафе	Cafe
Зочид буудал	Hotel
Төв шуудан	Central Post Office
Банк	Bank

Зах	Outdoor market
Сургууль	School
Бага сургууль	Elementary school
Дунд сургууль	Middle school
Ахлах сургууль	High school
Их сургууль	University
Дотуур байр	Dormitory
Цэцэрлэг	Kindergarten/garden
Эмнэлэг	Hospital
Мал эмнэлэг	Veterinary hospital
Амьтны хүрээлэн	Zoo
Амьтны дэлгүүр	Pet shop
Гутал засвар	Shoe repair shop
Цаг засвар	Watch repair shop
Дугуй засвар	Tire repair shop
Авто засвар	Auto repair shop
Авто сургууль	Driving school
Авто угаалга	Car wash
Дуурь, бүжгийн театр	Opera and ballet theatre
Драмын театр	Drama theatre
Кино театр	Cinema
Музей	Museum
Хуурай хими цэвэрлэгээ	Dry cleaning
Валют арилжаа	Currency exchange
Касс	Cashier
Билетийн касс	Ticket cashier office
Худалдааны төв	Shopping mall
Бөөний худалдаа	Wholesale
Торго, бөс бараа	Silk and fabrics
Гэр ахуйн бараа	Household goods
Алт мөнгөний дархан	Gold and silver smith
Даатгал	Insurance
Нотариат	Notary

Орчуулгын төв	Translation centre
Нүдний шил	Eyeglasses
Иог, бясалгалын төв	Yoga and meditation centre
Сургалтын төв	Training centre
Гал команд	Fire department
Шүүх	Court
Элчин сайдын яам	Embassy
Оршуулгын газар	Cemetery
Нийтийн бие засах газар	Public toilet
Ширээний теннис	Table tennis
Билльярд	Billiards
Түлхүүр олшруулна	Key duplicator
Гэрээт борлуулагч	Distributor
Хувцас захиалга, засвар	Ordering and mending clothes
Зурагчин	Photographer
Дүүрэг	District
Хороо	Subdistrict
Гэр хороолол	Ger district
Өрхийн эмнэлэг	Family clinic
Цагдаагийн хэлтэс	Police station

Зарим тэмдэглэгээ **Some designations**

Нээлттэй	Open
Хаалттай	Closed
Тат	Pull
Түлх	Push
Зарна	For sale
Утасны нэгж	Phone unit sales
Цагийн хуваарь	Timetable
Хямдрал	Sale
Тамхигүй бүс	No smoking zone
Орох	Entry

Гарц/Гарах	Exit
Орц	Entrance
Орохыг хориглоно!	No entry!
Машин тавихыг хориглоно!	No parking!
Хаалга хааж машин тавихыг хориглоно!	No blocking the door by parking a car!
Тамхи татахыг хориглоно!	No smoking!
Болгоомжтой!	Caution!
Аюултай!	Danger!
Хог бүү хая!	No littering!

Тэмдэг нэр / **Adjectives**

Цэвэр хот	Clean city
Бохир хот	Dirty city
Дуу чимээтэй хот	Noisy city
Орчин үеийн барилга	Modern building
Уламжлалт хэв маяг	Traditional style
Хоцрогдсон технологи	Outdated technology
Дэвшилтэт технологи	Advanced technology
Утаатай/утаагүй хот	Smoky/non-smoky city
Аюултай/аюулгүй газар	Dangerous/safe place
Зохион байгуулалт сайтай хот	Well organized city
Зохион байгуулалт муутай хот	Poorly organized city

***** *****

Дэлгүүр хайх	To look for a shop
Хайсан газраа олох	To find the place looking for
Хот өргөжин тэлэх	City to be expanded
Шинэ барилга баригдах	New buildings to be built
Хоттой танилцах	To get to know a city

Хотод төөрөх	To get lost in a city
Хотын иргэн болох	To become a citizen of a city
Хүүхдүүдэд замын хөдөлгөөний дүрэм заах	To teach about traffic rules to children
Улаан/шар гэрэл асах	Red/yellow light (to be) on
Ногоон гэрэл асах	Green light (to be) on
Зам (хөндлөн) гарах	To cross a road
Ногоон гэрлээр зам гарах	To cross a road with a green light
Явган хүний гарцаар зам гарах	To cross a road on a cross walk
Явган хүний замаар алхах	To walk on the sidewalk
Гэрэл солигдох	Light to be changed
Зам түгжрээтэй байх	Road to have a traffic jam
Машин жолоодох	To drive a car
Явган зорчигчдод зам тавьж өгөх	To stop to give chance to pedestrians to cross the road
Машин сигналдах	To beep/honk car horn
Хурдаа нэмэх/хасах	To speed up/slow down
Тоормослох	To brake
Хурд хэтрүүлэх	To speed up over the limit
Урсгал сөрж явах	To go against the flow
Согтуугаар машин барих	To drive after drinking
Осол гаргах	To cause an accident
Осолд орох	To get into an accident
Хурдны замаар давхих	To drive on the highway
Машинаа зогсоол дээр тавих	To park one's car in the parking lot
Зогсоолгүй газар тавьсан машиныг ачих	To tow away a car that is parked in a place with no parking lot

Орон, зүг чиг заасан үгс

Postpositions and Directions

Хаана

Where

Ширээн дээр	On the table
Ширээн доор	Under the table
Хайрцган дотор	Inside the box
Гэрийн хажууд	Next to the ger
Миний дэргэд	Beside me
Гэрийн урд/өмнө	In front of the ger
Гэрийн ард/хойно	Behind the ger
Гэрийн наана	On this side of the ger
Гэрийн цаана	On that side of the ger
Хайрцгийн/хайрцагны дээд тал(д)	On the top side of the box
Хайрцагны доод тал(д)	On the bottom side of the box
Хайрцагны дотор тал(д)	Inside the box
Хайрцагны баруун тал(д)	On the right/west side of the box
Хайрцагны зүүн тал(д)	On the left/east side of the box
Хайрцагны урд тал(д)	In the front side of the box
Хайрцагны ар тал(д)	In the back side of the box
Урд зүг(т)	To the south
Хойд зүг(т)	To the north
Баруун зүг(т)	To the west
Зүүн зүг(т)	To the east
Гэрийн гадаа/гадна	Outside of the ger
2 модны хооронд	In between 2 trees
2 модны дунд/голд	In the middle of 2 trees
Энд	Here
Тэнд	There

*****	*****
Гэрийн хажууд мод байна.	There is a tree next to the ger.
Хүүхэд ширээн дээр зогсож байна.	The child is standing on the table.
Багш гэрийн наана суусан.	The teacher sat down on this side of the ger.
Намайг гэрийн гадна хүлээж байгаарай.	Please be waiting for me outside of the ger.
Энэ сандлыг 2 модны голд тавиарай.	Please put this chair in between the two trees.
Хаашаа	**To/towards where**
Дээш(ээ)	Up
Доош(оо)	Down
Арагш(аа)/хойшоо	To the north/back
Урагш(аа)	To the south/forwards
Хажуу тийш(ээ)	Sideways
Баруун тийш(ээ)	To the west
Зүүн тийш(ээ)	To the east
Нааш(аа)	This way
Цааш(аа)	That way
Гадагш(аа)	Outside
Дотогш(оо)	Inside
Ийш(ээ)	This way
Тийш(ээ)	That way
*****	*****
Дээшээ хараарай.	Please look up.
Наашаа яваарай.	Please go this way.
Нааш ир.	Come here.
Урагшаа хурдан гүй.	Run forwards fast.
Битгий ийш тийш хар.	Don't look here and there.
Баруун тийшээ эргэ.	Turn to the west.

Хүүхдүүд нааш цааш гүйлдээд байна.	Kids keep running this way and that way.
Хүмүүс дотогшоо орсон.	People went inside.
Хүмүүс гадагшаа гарсан.	People went outside.

Хаагуур	**By where, by __ side**
Гүүрэн дээгүүр	Over the bridge
Гүүрэн доогуур	Under the bridge
Гэрийн ардуур/хойгуур	Behind the ger
Гэрийн урдуур/өмнүүр	In front of the ger
Гэрийн хажуугаар	Beside the ger
Гэрийн баруун талаар	By the west side of the ger
Гэрийн зүүн талаар	By the east side of the ger
Гэрийн наагуур	By this side of the ger
Гэрийн цаагуур	By that side of the ger
Гэрийн гадуур	Outside the ger
Гэр(ийн) дотуур	Inside the ger
2 модны хоорондуур	Between 2 trees
2 модны дундуур/голоор	Between 2 trees
Модны энүүгээр	By this side of the tree
Модны тэрүүгээр	By that side of the tree

*****	*****
Би гүүрэн дээгүүр гарсан.	I went over the bridge.
Гүүрэн доогуур нэг машин өнгөрч байна.	One car is passing under the bridge.
Би гэрийн цаагуур гүйсэн.	I ran by that side of the ger.
Тэд гэрийн урдуур өнгөрсөн.	They passed by the front side of the ger.
Тэд 2 модны дундуур гарах байх.	Probably they will pass between two trees.
Хүмүүс гэрийн гадуур холхиж байна.	People are going back and forth outside the ger.

Хүнсний дэлгүүр — Supermarket

Хүнсний дэлгүүр	Supermarket
Худалдагч	Salesman/saleswoman
Худалдан авагч	Customer/shopper
Касс	Cashier
Хөнгөлөлтийн карт	Discount card
Бонус карт	Bonus card
Хариулт мөнгө	Change
Задгай мөнгө	Small notes
Бүхэл мөнгө	Big notes
Хадгалах хугацаа	Storage period/expiry date
Үйлдвэрлэсэн огноо	Manufactured date
Дуусах хугацаа	Expiry date/best before
Найрлага	Ingredients
Хэрэглэх заавар	Usage instruction
Тор	Shopping bag
Гялгар уут	Plastic bag
Түрдэг тэрэг	Trolley
Сагс	Basket
Лангуу	Counter
Тавиур	Shelf

Мах	**Meat**
Үхрийн мах	Beef
Үхрийн хавирга	Beef rib
Хонины мах	Mutton
Хонины гуя	Sheep thigh
Хонины сүүл	Sheep fat tail
Хонины ууц	Sheep rump
Хонины элэг	Sheep liver
Адууны мах	Horse meat
Ямааны мах	Goat meat
Тэмээний мах	Camel meat

Гэдэс	Intestines
Цувдай	Offal
Тахианы мах	Chicken (meat)
Тахианы гуя	Chicken leg
Тахианы мөч	Chicken joint
Тахианы цээж	Chicken breast
Гахайн мах	Pork
Гахайн утсан мах	Bacon
Цацагт хяруулын мах	Turkey
Ястай мах	Meat with bone
Цул/ясгүй мах	Boneless meat
Өөхтэй мах	Meat with fat
Өөхгүй/хар мах	Meat with no fat
Гол мах	Fillet
Хиам/зайдас	Sausage
Борц	Dried meat

Далайн хоол	**Seafood**
Загас	Fish
Түрс	Caviar/roe
Сардин загас	Sardine
Хавч	Lobster
Сам хорхой	Shrimp
Хясаа	Clam

Жимс, жимсгэнэ	**Fruit and berries**
Алим	Apple
Гадил/банан	Banana
Хан боргоцой	Pineapple
Жүрж	Orange
Бэрсүүт жүрж/мандарин	Mandarin
Киви	Kiwi
Нимбэг/лимон	Lemon
Тарвас	Watermelon

Амтат гуа	Melon
Лийр	Pear
Анар	Pomegranate
Чавга	Plum
Интоор	Cherry
Тоор	Peach
Манго	Mango
Чангаанз	Apricot
Үзэм	Raisin
Усан үзэм	Grape
Гүзээлзгэнэ	Strawberry
Үхрийн нүд	Black currant
Тошлой	Gooseberry
Нэрс	Blueberry
Цангис	Cranberry
Бөөрөлзгөнө	Raspberry
Бөлжиргөнө	Blackberry
Аньс	Cowberry
Чацаргана	Sea buckthorn

Самар	**Nut**
Бүйлс	Almond
Хушга	Walnut
Хушны самар	Pine nut
Наргилын самар	Coconut

Ногоо	**Vegetables**
Төмс	Potato
Амтат төмс	Sweet potato
Сармис	Garlic
Лууван	Carrot
Сонгино	Onion
Байцаа	Cabbage

Цэцэгт байцай	Cauliflower
Урт байцай	Chinese cabbage
Манжин	Turnip
Хулуу	Squash
Пампкин	Pumpkin
Мөөг	Mushroom
Брокколи	Broccoli
Зираа	Lettuce
Бууцай	Spinach
Шанцай	Lettuce
Базилик	Basil
Гаа(т өвс)	Mint
Цагаан гаа	Ginger
Лаврын навч	Bay leaves
Ногоон гоньд	Dill
Яншуй	Coriander
Эрдэнэшиш	Sweet corn
Дун ногоо	Stachy plant
Вандуй	Peas
Шош	Beans
Шар буурцаг	Soybeans
Шар буурцгийн соёолж	Soybean sprouts

Жимст ногоо	**Fruit vegetables**
Өргөст хэмх	Cucumber
Хаш	Eggplant
Амтат чинжүү	Sweet pepper
Халуун чинжүү	Hot pepper
Улаан лооль	Tomato
Чидун	Olive
Авокадо	Avocado
Цүккини	Zucchini
Хулуу	Pumpkin

Уух зүйлс	**Drinks**
Ус	Water
Сүүтэй кофе	Milk coffee
Хар кофе	Black coffee
Ундаа	Soft drink
Газтай ундаа	Carbonated drink
Цай	Tea
Сүүтэй цай	Milk tea
Ногоон цай	Green tea
Хар цай	Black tea
Жимстэй цай	Fruit tea
Өтгөн цай	Strong tea
Шүүс	Juice
Рашаан	Mineral water
Архи	Vodka
Шар айраг/пиво	Beer
Дарс/вино	Wine
Оргилуун дарс	Champagne
Шампанск	Champagne
Ликёр	Liqueur
Виски	Whiskey
Коктейль	Cocktail
Коньяк	Cognac

Цагаан идээ	**Milk products**
Сүү	Milk
Тараг	Yoghurt
Бяслаг	Cheese
Зөөхий	Sour cream
Масло	Butter
Шар тос	Traditional butter
Хайлмаг	Melted butter with flour and sugar

Аарц	Sour curd
Ааруул	Dried curd
Ээдэм	Curd cheese
Өрөм	Clotted cream
Ээзгий	Milk product made by boiling most of the whey from curdled milk
Хоормог	Fermented camel milk
Айраг	Fermented horse milk
Хярам	Boiled milk diluted with water
Нэрмэл архи	Distilled vodka

Бусад зүйлс	**Other things**
Цагаан будаа	White rice
Шар будаа	Millet
Хөц будаа	Pearl barley
Гурвалжин будаа	Buckwheat
Гурил	Flour
Хэрчсэн гурил	Flattened and sliced dough
Гоймон	Noodles
Бэлэн гоймон	Instant noodles
Туузан гоймон	Fettuccine
Шпагетти	Spaghetti
Дун гоймон	Snail shaped noodles
Мушгиа гоймон	Spiral noodles
Хөндий гоймон	Hollow noodles
Бялуу/торт	Cake
Талх	Bread
Боорцог/боов	Pastry/bun
Жигнэмэг	Biscuits
Овьёос	Oats
Амуу будаа	Cereal

Ёотон	Lump sugar
Тос	Oil
Хуурай сүү	Powdered milk
Зайрмаг/мөхөөлдөс	Ice cream
Өндөг	Egg
Чихэр	Candy
Шоколад	Chocolate
Дүрдэг цай	Tea bag
Жимсний чанамал	Jam
Варень	Jam (Russian word)

Амтлагч	**Condiments/seasonings**
Элсэн чихэр	Sugar
Давс	Salt
Майонез	Mayonnaise
Кетчуп	Ketchup
Цуу	Vinegar, sauce
Цагаан цуу/уксус	White vinegar
Гич	Mustard
Хар чинжүү/перец	Black pepper
Улаан чинжүү/перец	Red pepper
Салат амтлагч	Salad dressing
Мах амтлагч	Meat dressing
Бууз амтлагч	Buuz dressing

***** *****

Өнөөдөр ирсэн шинэ талх байгаа юу?	Do you have fresh bread that just came today?
Энэ барааны хугацаа нь дуусчихжээ. Хугацаа нь дуусаагүй ийм бараа байгаа юу?	The date of this product has expired. Do you have the same product that isn't out of date?

Ногоо киллүүлэх гэсэн юм. Хаана киллүүлэх вэ?	I want to have these vegetables weighed. Where can I have them weighed?
Сүү хаана байдаг юм бэ? Би олдоггүй ээ.	Where is the milk? I can't find it.
Хайрцаг нь эвдрээгүй чокопай байгаа юу?	Do you have any choco pies with undamaged packages?
Энэ хэд вэ? Үнэ нь алга байна. Үнийг нь (уншуулаад) хараад өгөөч.	How much is this? There is no price tag. Can you scan it to see its price for me?
Лангуу, касс хоёрын үнийн дүн зөрүүтэй байна.	The counter and cashier prices are different.
Авсан бараагаа буцаах гэсэн юм.	I want to return the product that I purchased.
Авсан бараагаа солиулах гэсэн юм.	I want to exchange the product that I purchased.
Хөнгөлөлтийн карт байгаа юу?	Do you have a discount card?
Байгаа/байхгүй.	I have one./I don't have one.
Бонусаа хасах уу?	Do you want to use your bonus?
(Бонусаа) хасна аа.	Yes, I want to use it.
(Бонусаа) хасахгүй ээ.	No, I don't want to use it.
Нууц дугаараа хийгээрэй.	Enter your password here.
Тор авах уу?	Do you want a bag?
Тооцоогоо картаар хийх үү, бэлнээр хийх үү?	Do you want to pay by card or cash?
Баримт хувь хүнээр үү, байгууллагаар уу?	Is the receipt for an individual or an organization?

Худалдааны төв — Shopping Mall

Тасгууд — Shops

Тоглоомын тасаг	Toyshop
Эмэгтэй хувцасны тасаг	Women's clothes shop
Эрэгтэй хувцасны тасаг	Men's clothes shop
Гоо сайхны барааны тасаг	Cosmetics shop
Цагны тасаг	Watch shop
Номын тасаг	Bookshop
Нүдний шилний тасаг	Opticians
Биеийн тамирын хувцасны тасаг	Sport clothes shop
Аяны хэрэгслийн тасаг	Travel equipment shop
Бичиг хэргийн тасаг	Stationary shop
Цахилгаан барааны тасаг	Electronics shop
Хөгжмийн зэмсгийн тасаг	Musical instruments shop
СиДи-ний тасаг	CD shop
Гутлын тасаг	Shoe shop
Малгайн тасаг	Hat shop
Гэр ахуйн барааны тасаг	Home equipment shop
Ор, дэрний хэрэгслийн тасаг	Bedroom goods shop
Бөс даавууны тасаг	Fabric shop
Нэгдүгээр давхар	First floor
Урсдаг шат	Escalator
Энгийн шат	Stairs
Цахилгаан шат/лифт	Lift

Хувцас	Clothes
Малгай	Cap/hat/hood
Ноосон малгай	Stocking cap/woollen hat
Бүрх малгай	Felt hat/boater
Нарны малгай	Sun hat
Саравчтай малгай	Peak cap
Тоорцог	Skullcap
Угладаг малгай	Balaclava
Ороолт/алчуур	Scarf
Зангиа	Tie
Эрвээхэй зангиа	Bow tie
Бээлий	Gloves
Хуруугүй бээлий	Mittens
Савхин бээлий	Leather gloves
Ноосон бээлий	Stocking/woollen gloves
Нэхий бээлий	Sheepskin gloves
Цамц	Shirt/sweater
Хоолойтой цамц	Crewneck jumper
Малгайтай цамц	Hooded top
Коовт	Classic blouse
Футболка [подволк]	T-shirt
Даашинз	Dress
Платье [палааж]	Dress
Хүрэм	Jacket
Костюм/хослол	Suit
Куртка [күүрчиг]	Short coat
Пальто	Long/over coat
Нэхий дээл	Sheepskin jacket
Цув	Trench coat
Пиджак	Formal jacket
Хантааз	Waistcoat
Нөмрөг	Cape

Нөмрөг цув	Cardigan
Биеийн тамирын хувцас	Tracksuit
Гэрийн халат [халаат]	Housedress
Усны хувцас	Swimsuit
Борооны цув	Raincoat

Өмд	Pants
Мөрөвчтэй өмд	Overalls
Жийнс	Jeans
Шоорт	Shorts
Банзал/юбка [юбк]	Skirt
Өмдөн юбка	Culottes
Тэлээ/бүс	Belt
Мөрөвч	Suspenders
Урт оймс	Long socks
Богино оймс	Ankle length socks
Шилэн оймс	Stockings (thin)
Шилэн трико	Panty hose
Ботинк	Shoes
Туфли [туфл]	High heel shoes
Сандаал	Sandals
Углааш	Clogs
Гэрийн шаахай	Slippers
Пүүз	Sport boots
Кээт	Tennis shoes
Гутал	Boots
Хагас түрийтэй гутал	Ankle boots
Буузан гутал	Moccasin
Бойтгон гутал	Booties, flat shoes
Уулын гутал	Hiking boots
Ажлын гутал	Heavy-duty boots
Усны гутал	Rain boots

Дотуур хувцас	Underwear
Майк	Tank top
Сарафан	Foundation slip
Хөхний даруулга/лифчик	Bra
Бандааш	Underpants
Дотуур өмд	Drawers
Унтлагын хувцас	Pyjamas

Гоёл, чимэглэл	Accessories
Ээмэг	Earrings
Бөгж	Ring
Хүзүүний зүүлт	Necklace
Гинж	Chain
Бугуйн цаг	Wristwatch
Бугуйвч	Bracelet
Гоёлын сүлбээр	Brooch
